



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэбүрэн сумын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2025/044/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2025 он</p>	<p>Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Бадрал Утас:70432545 Цахим хаяг: munkhtulgad@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2025.02.24 № 2/59
танай _____ -ны № _____ -т

ХОВД АЙМГИЙН ЭРДЭНЭБҮРЭН СУМЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Г.ПҮРЭВ-ОЧИР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэбүрэн сумын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Цагийн бүртгэлийг үнэн зөв, бүрэн хөтлөөгүй, цалин хөлсийг цагийн бүртгэлээс зөрүүтэй олгосон;
- 2024 онд 7,320.0 мянган төгрөгийн шатахуун худалдан авч зарцуулсан бөгөөд шатахууны тооцоо бодолгүйгээр зарлага гаргасан;
- Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй;
- Тайлант онд дотуур байрны хүүхдийн хоолны зардалд 57,335.6 мянган төгрөг, үдийн хоолны зардалд 29,543.8 мянган төгрөгийг шууд гэрээ байгуулан худалдан авсан;

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд үдийн цай, дотуур байрны хоол хүнсний зардалд 90,327.7 мянган төгрөг батлагдаж, 86,879.3 мянган төгрөгийг зарцуулсан, түлш халаалтын зардал 244,991.9

мянган төгрөг зарцуулж өнгөрсөн оноос өнгөрсөн оноос 26.5 хувиар өссөн нь халаалтын тарифын үнэ 2475 төгрөгөөс 3070 төгрөг болж өссөнтэй холбоотой байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд төрийн албан хаагчийн цалин хөлс нэмэгдсэн ба улсын төсвөөс 1,166,982.6 мянган төгрөг батлагдаж, 1,117,803.7 мянган төгрөгийг зарцуулсан нь өмнөх оноос 36.0 хувиар өссөн, 2024 онд 2 дугаар түвшинд 5 багш, 3 дугаар түвшинд 6 багш, нийт 11 багш гүйцэтгэлээр үнэлэгдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 7 зорилтын хүрээнд 73 дэд арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн гүйцэтгэлийг тооцон дээд шатны байгууллагад хүргүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР


Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>132,266,552.17</u>	<u>173,986,978.72</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	43,660,751.31	69,472,850.71
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	43,660,751.31	69,472,850.71
3121	Төгрөг	43,660,751.31	69,472,850.71
31211	Төрийн сангийн харилцах	43,660,751.31	69,472,850.71
33	АВЛАГА	408,718.66	6,389,325.41
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	408,718.66	6,389,325.41
35	БАРАА МАТЕРИАЛ	88,197,082.20	97,409,572.60
351	Түүхий эд материал	299,000.00	299,000.00
35130	Эм боох материал	299,000.00	299,000.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	3,291,799.00	3,741,955.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	-	124,420.00
354	Хангамжийн материал	84,606,283.20	93,244,197.60
35410	Бичиг хэргийн материал	462,000.00	-
35420	Аж ахуйн материал	67,480,742.60	66,277,437.60
35460	Хүнсний материал	2,029,260.60	12,332,480.00
35470	Бусад хангамжийн материал	14,634,280.00	14,634,280.00
36	НӨӨЦИЙН БАРАА	-	715,230.00
36600	Бусад нөөц	-	715,230.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,288,024,975.24</u>	<u>1,485,325,652.92</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,288,024,975.24	1,485,325,652.92
392	Биет хөрөнгө	1,229,946,850.16	1,427,247,528.00
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,297,669,449.00	1,297,669,449.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(315,556,337.00)	(399,230,065.64)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	353,030,665.00	516,335,082.10
39206	Хуримтлагдсан элэгдэл	(205,759,820.94)	(225,486,768.43)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	156,223,398.60	297,608,808.70
39208	Хуримтлагдсан элэгдэл	(92,611,850.70)	(100,617,571.53)
39217	Ном	36,951,346.20	40,968,593.80
393	Биет бус хөрөнгө	58,078,125.08	58,078,124.92
39301	Програм хангамж	625,000.00	625,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(546,874.92)	(546,875.08)
39303	Бусад биет бус хөрөнгө	58,000,000.00	58,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,420,291,527.41</u>	<u>1,659,312,631.64</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>5,133,620.18</u>	<u>3,131,023.62</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,133,620.18	3,131,023.62
413	Өглөг	5,133,620.18	3,131,023.62
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,846,709.83	2,573,243.27
4136	Бусад өглөг	2,286,910.35	557,780.35
41361	Байгууллагад төлөх өглөг	2,286,910.35	557,780.35
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,415,157,907.23</u>	<u>1,656,181,608.02</u>

51	Засгийн газрын хувь оролцоо	1,415,157,907.23	1,656,181,608.02
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	652,388,518.00	652,388,518.00
51101	Өмч: - төрийн	652,388,518.00	652,388,518.00
512	Хуримтлагдсан үр дүн	(93,318,316.77)	147,705,384.02
51210	Өмнөх үеийн үр дүн	(93,318,316.77)	(93,318,316.77)
51220	Тайлант үеийн үр дүн	-	241,023,700.79
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	856,087,706.00	856,087,706.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,420,291,527.41</u>	<u>1,659,312,631.64</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(Төгрөгөөр)			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,378,866,813.30	2,015,745,174.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	68,314,513.30	283,658,074.80
120	Нийтлэг татварын бус орлого	68,314,513.30	283,658,074.80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	672,003.00	283,658,074.80
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	749,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	521,355.00	282,909,074.80
120005	Түрээсийн орлого	476,800.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	48,693,045.30	-
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	18,472,665.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,310,552,300.00	1,732,087,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,097,675,100.00	1,453,809,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,097,675,100.00	1,453,809,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,000,000.00	18,027,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	4,081,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	13,946,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	207,877,200.00	260,250,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	207,877,200.00	260,250,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,385,821,657.33	1,774,721,474.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,385,821,657.33	1,774,721,474.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,352,154,790.13	1,739,646,613.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	827,266,218.81	1,116,365,398.61
210101	Үндсэн цалин	601,992,274.06	741,006,796.65
210102	Нэмэгдэл	193,813,110.64	328,260,141.96
210104	Урамшуулал	31,460,834.11	47,098,460.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	102,900,735.49	139,264,406.93

Эрдэнэбүрэн сумын Сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210201	Тэтгэврийн даатгал	70,735,628.80	94,891,059.04
210202	Тэтгэмжийн даатгал	8,272,662.32	11,163,653.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,618,129.69	5,689,807.44
210204	Ажилгүйдлийн даатгал	1,570,392.35	5,503,977.28
210205	Эрүүл мэндийн даатгал	15,703,922.33	22,015,909.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	201,079,848.00	254,450,993.00
210301	Гэрэл, цахилгаан	7,161,748.00	9,359,093.00
210302	Түлш, халаалт	193,568,100.00	244,991,900.00
210303	Цэвэр, бохир ус	350,000.00	100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	33,727,885.75	39,183,695.00
210401	Бичиг хэрэг	9,413,048.00	10,639,700.00
210402	Тээвэр, шатахуун	5,237,275.75	7,320,230.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	459,250.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,910,850.00	2,288,836.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	18,934,929.00
210408	Бараа материал акталсны зардал	14,707,462.00	-
2105	Нормативт зардал	53,472,707.00	47,086,410.60
210502	Хоол, хүнс	53,472,707.00	47,086,410.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,487,250.00	-
210604	Урсгал засвар	2,487,250.00	-
2107	Томилолт, зочны зардал	2,890,000.00	-
210702	Дотоод албан томилолт	2,890,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,159,600.00	22,314,811.75
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	476,800.00	6,883,310.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,682,800.00	15,431,501.75
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	123,170,545.08	120,980,897.12
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,762,950.00	9,477,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	97,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	117,407,595.08	111,406,397.12
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,666,867.20	35,074,861.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,666,867.20	34,174,374.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	33,666,867.20	30,381,504.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	3,792,870.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	900,487.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	900,487.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(6,954,844.03)</u>	<u>241,023,700.79</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(6,954,844.03)</u>	<u>241,023,700.79</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
------------	----------	---------------------	-----------------------

1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,311,179,748.00</u>	<u>1,732,836,100.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	627,448.00	749,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	627,448.00	749,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	150,648.00	749,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	749,000.00
120005	Түрээсийн орлого	476,800.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,310,552,300.00	1,732,087,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,097,675,100.00	1,453,809,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,097,675,100.00	1,453,809,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,000,000.00	18,027,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	4,081,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	13,946,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	207,877,200.00	260,250,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	207,877,200.00	260,250,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,277,246,165.85</u>	<u>1,707,024,000.60</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,277,246,165.85	1,707,024,000.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,239,741,765.85	1,672,786,823.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	821,636,517.85	1,117,769,278.85
210101	Үндсэн цалин	566,605,971.74	667,620,092.62
210102	Нэмэгдэл	215,082,596.11	376,382,817.86
210104	Урамшуулал	39,947,950.00	73,766,368.37
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	105,928,400.00	143,714,600.00
210201	Тэтгэврийн даатгал	72,031,600.00	97,725,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,474,100.00	11,497,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,779,400.00	5,748,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,694,600.00	5,748,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,948,700.00	22,994,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	203,837,200.00	257,150,413.00
210301	Гэрэл, цахилгаан	9,069,100.00	10,175,513.00
210302	Түлш, халаалт	193,268,100.00	244,991,900.00
210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	1,983,000.00
2105	Нормативт зардал	49,488,200.00	57,335,550.00
210502	Хоол, хүнс	49,488,200.00	57,335,550.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,040,000.00	2,200,000.00
210604	Урсгал засвар	4,040,000.00	2,200,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,159,600.00	26,783,901.75
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	476,800.00	11,177,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,682,800.00	15,606,501.75

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	49,651,848.00	67,833,080.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	42,627,648.00	59,704,180.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,024,200.00	8,128,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,504,400.00	34,237,177.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	37,504,400.00	33,336,690.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	37,504,400.00	29,543,820.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	3,792,870.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	900,487.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	900,487.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>33,933,582.15</u>	<u>25,812,099.40</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	33,933,582.15	25,812,099.40
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		43,660,751.31
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	43,660,751.31	69,472,850.71

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	652,388,518.00	856,087,706.00	(93,318,316.77)	1,415,157,907.23
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	652,388,518.00	856,087,706.00	(93,318,316.77)	1,415,157,907.23
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	652,388,518.00	856,087,706.00	(93,318,316.77)	1,415,157,907.23
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	652,388,518.00	856,087,706.00	(93,318,316.77)	1,415,157,907.23
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	652,388,518.00	856,087,706.00	(93,318,316.77)	1,415,157,907.23
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	241,023,700.79	241,023,700.79
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	652,388,518.00	856,087,706.00	147,705,384.02	1,656,181,608.02

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Төгрөгөөр)			
Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл

2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,778,120,900.00	1,706,123,513.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,778,120,900.00	1,706,123,513.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,742,804,300.00	1,672,786,823.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,166,982,600.00	1,117,769,278.85
210101	Үндсэн цалин	756,332,900.00	667,620,092.62
210102	Нэмэгдэл	380,155,800.00	376,382,817.86
210104	Урамшуулал	30,493,900.00	73,766,368.37
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	145,872,900.00	143,714,600.00
210201	Тэтгэврийн даатгал	99,193,500.00	97,725,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	11,669,700.00	11,497,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,835,000.00	5,748,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	5,835,000.00	5,748,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	23,339,700.00	22,994,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	258,050,900.00	257,150,413.00
210301	Гэрэл, цахилгаан	11,076,000.00	10,175,513.00
210302	Түлш, халаалт	244,991,900.00	244,991,900.00
210303	Цэвэр, бохир ус	1,983,000.00	1,983,000.00
2105	Нормативт зардал	59,397,300.00	57,335,550.00
210502	Хоол, хүнс	59,397,300.00	57,335,550.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,200,000.00	2,200,000.00
210604	Урсгал засвар	2,200,000.00	2,200,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,889,000.00	26,783,901.75
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,275,000.00	11,177,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	19,614,000.00	15,606,501.75
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	82,411,600.00	67,833,080.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	73,832,700.00	59,704,180.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,578,900.00	8,128,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,316,600.00	33,336,690.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,316,600.00	33,336,690.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	30,930,400.00	29,543,820.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,386,200.00	3,792,870.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,778,120,900.00	1,731,935,613.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,453,809,200.00	1,453,809,200.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,453,809,200.00	1,453,809,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,651,000.00	18,027,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,081,000.00	4,081,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,570,000.00	13,946,000.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	260,250,900.00	259,350,413.00
132001	Орон нутгийн төсвөөс	260,250,900.00	259,350,413.00

120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	44,409,800.00	749,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	749,000.00	749,000.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	43,660,800.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		43,660,751.31
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		69,472,850.71

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 173,228.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 74,199.4 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Санхүү байдлын тайланд авлага - 4.678.6 мянган төгрөг, үндсэн хөрөнгө – 31,612.2 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.
- Мөнгөн гүйлгээ төсвийн гүйцэтгэлээс зөрүүтэй тайлагнасан-2,950.6 мянган төгрөг
- Үр дүнгийн тайланд зардлыг зөрүүтэй тусгасан-34,957.8 мянган төгрөг.

Залруулагдаагүй нийт 99,028.8 мянган төгрөгийн 5 зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 99,028.8 мянган төгрөгийн 5 зөрчил² илэрснээс, 94,199.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгч, 4,829.2 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

3.1 Төлбөрийн акт

3.1.1 Тайлант онд хэрэгжсэн сүү хөтөлбөрийн хүрээнд хэмнэгдсэн зардлыг төсөвт буцаан төвлөрүүлээгүй 3,517,000 төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-д “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, 45.2.1-д “нэгжид ногдох норм, нормативаар тооцон төсвийг нь баталсан ба гүйцэтгэл нь анх тооцсон нэгжийн тоо хэмжээнээс бага бол”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон

3.1.2 2024 онд ажилтнуудад 1,311,600 төгрөгийн цалин хөлс, нэмэгдлийг үндэслэлгүйгээр илүү тооцон олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 28.6-д “Аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн харьяа нутаг дэвсгэр дэх төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захирлыг томилж, хуульд заасан үндэслэлээр чөлөөлнө”, 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалтуудыг тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.2.1 Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд дотуур байрны хүүхдийн хоолны зардалд 57,335.6 мянган төгрөг, үдийн хоолны зардалд 29,543.8 мянган төгрөгийг шууд гэрээ байгуулан худалдан авсан байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т “Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолоор Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаарыг шинэчлэн тогтоосон тогтоолын дагуу босго үнээс давсан барааг худалдан авахдаа худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажиллах.

3.2.2 Дотоод хяналт хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: 2024 онд 7,320.0 мянган төгрөгийн шатахуун худалдан авч зарцуулсан бөгөөд шатахууны тооцоо бодолгүйгээр зарлага гаргасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар баталсан жишиг нормтой нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Жишиг, нормын дагуу тооцоог бодож, санхүүгийн тайланд тусгах.

3.2.3 Дотоод хяналт хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Цагийн бүртгэлийг үнэн зөв, бүрэн хөтлөөгүй, цалин хөлсийг цагийн бүртгэлээс зөрүүтэй олгосон, хүнсний талон журнал хөтлөлт хангалтгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цагийн бүртгэлийг үнэн зөв бүртгэх, анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Эрдэнэбүрэн сумын сургууль	Санхүү байдлын тайланд авлага - 4.678.6 мянган төгрөг, үндсэн хөрөнгө - 31.612.2 мянган төгрөгөөр дутуу тусгасан.	1	36,290.9	1	36,290.9			1	36,290.9				
	Мөнгөн гүйлгээ төсвийн гүйцэтгэлээс зөрүүтэй тайлагнасан.	1	2,950.6			1	2,950.6	1	2,950.6				
	Үр дүнгийн тайланд зардлыг зөрүүтэй тусгасан	1	34,957.9			1	34,957.9	1	34,957.9				
ДҮН		3	74,199.4	1	36,290.9	2	37,908.5	3	74,199.4				

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12

Эрдэнэбүрэн сумын сургууль	Тайлант онд хэрэгжсэн сүү хөтөлбөрийн хүрээнд хэмнэгдсэн зардлыг төсөвт буцаан төвлөрүүлээгүй	1	3,517.6	1	3,517.6					
	Ажилтнуудад цалин хөлс, нэмэгдлийг үндэслэлгүйгээр илүү тооцон олгосон.	1	1,311.6	1	1,311.6					
	Шатахууны тооцоо бодоогүйгээр бараа материалаас зарлага гаргасан	1	7,320.2				1	7,320.2		
	Цагийн бүртгэлийг үнэн зөв, бүрэн хөтлөөгүй, цалин хөлсийг цагийн бүртгэлээс зөрүүтэй олгосон, хүнсний талон журнал хөтлөлт хангалтгүй байна.	1	-				1	-		
Нийт дүн		4	12,149.4	2	4,829.2			2	7,320.2	

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:					
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10
Эрдэнэбүрэн сумын сургууль	Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй	1	86,879.4					1	86,879.4
Нийт дүн		1	86,879.4					1	86,879.4

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1				1		